

Бичсэн hanoi

2016 оны 1-р сарын 15, Баасан гариг, 08:15 -

---



Улаанбаатар дахь Дипломат корпусын төлөөлөгчдийн газрын тэргүүн нарт шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлэв

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, УИХ-ын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн нар оноодор Улаанбаатар дахь Дипломат корпусын төлөөлөгчдийн газрын тэргүүн нарыг хвлээн авч шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлэв.

Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн үгэндээ “Дипломат корпусын ахлагч Эрхэм Элчин сайд аа,

Эрхэм Элчин сайд, Түр хамаарагч нар аа,

Эрхэмсэг хатагтай, ноёд оо,

Уламжлал ёсоор Та бүхэнтэй шинэ он гаргаад уулзаж байгаадаа болон Улаанбаатар дахь Дипломат корпус ам бүл нэмэгдэж байгаад бид баяртай байна.

Шинэ он гаргаад бид уулзаж байгаа нь олзий дэмбэрэлтэй учрал юм. Бид шинэ оноо угтаад удаагүй байгаагаас гадна бас Монголын цагаан сар дохсон, Цагаан сарын уур амьсгал залгасан үед уулзалдаж байгаа энэ мочийг ашиглан Эрхэм Та бүхэнд, Та

Бичсэн hanoi

2016 оны 1-р сарын 15, Баасан гариг, 08:15 -

---

бүхнээр уламжлан Танай бүх дипломатчдад, гэр бүлийнхэнд, улмаар Та бүхний толоолон суугаа улс орны иргэдэд шинэ 2016 оны шинэ жилийн баярын мэнд, мон ирж буй мичин жилийн Цагаан сарын баярын мэндийг хамтатган дэвшүүлье.

Бид 2015 оноо амжилт бүтээлээр үдлээ. Гадаад харилцаа маань ч идэвхтэй байлаа. НҮБ-ын Хүний эрхийн зовлолийн сонгуульд ялсан, гадаад сурталчилгааны болон эдийн засгийн гадаад харилцааны хотолбороо хэрэгжүүлж эхэлсэн, гурван талт коридор байгуулах ажил дуусч байна, Монгол-Япон-АНУ-ын гурван талт уулзалт хийсэн, “Эдийн засгийн түншлэлийн тухай” Монгол, Японы хоорондын хэлэлцээр байгуулж, батлуулсныг энд жишээ болгон дурдаж болох юм.

Шинэ 2016 он маань бүр ч их ачаалалтай, бүтээл арвинтай жил болно.

Шинэ 2016 онд Монголын улс тор-нийгмийн амьдралд хоёр чухал үйл явдал бараг давхцан тохионо.

Монголчууд парламентын ээлжит 7 дахь сонгуулиа явуулна. Энэ сонгууль Монголын ард түмний ойрын жилүүдийн хөгжил дэвшлийн хувь заяаг тодорхойлох тул түүнд Монголын тор-засаг онцгой ач холбогдол огно. Монголчууд улс тор-эдийн засгийн салбарт хос шилжилтийг амжилттай хийсэн туршлагатай, энэ хэрээрээ ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгт нэр хүндтэй, дэлхийд ардчиллаараа хошуучлагчдын эгнээнд явдаг орны хувьд энэ жилийн сонгууль ардчиллын түүхийн маань томхон үйл явдал болно. Манай улс торийн бүх нам, иргэд сонгогчид сонгуульдаа идэвхтэй оролцож, хууль дүрмээ ягштал биелүүлж чадна гэдэгт итгэлтэй байна. Бидний энэ туршлагыг бүс нутгийн хэмжээнд үнэлж, үлгэрлэн дагаж байна.

Шинэ 2016 онд монголчууд бид Ази-Европын чуулга уулзалт болох – АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтыг эх орондоо зохион байгуулах зочин улсын хүндтэй үүргийг оортоо аваад байна. АСЕМ-ийн дээд хэмжээний энэхүү уулзалт нь АСЕМ-ийн 20 жилийн ойтой давхцах тул ойн арга хэмжээ, уулзалт маань зэрэгцэн явагдана. Манай Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний комисс, ГХЯ, АСЕМ-ийн бэлтгэл хангах ажлын алба нэн идэвхтэй ажиллаж байна.

АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалтад уригдсан Ази, Европын улсуудын Элчин сайд нар

Бичсэн hanoi

2016 оны 1-р сарын 15, Баасан гариг, 08:15 -

---

Та бүхэн энэ уулзалтад онцгой ач холбогдол огч, хамтран ажиллаж байгаад бид баяртай байна. Та бүхний толоолон суугаа улс орны Тор-засгийн тэргүүн нар Улаанбаатарт тавтай саатан морилно гэдэгт бид итгэлтэй байна.

Эрхэм ноёд хатагтай нар аа,

Миний бие Монгол Торийн тэргүүний хувиар Монгол Улс байнга товийг сахих тухай санаачилгаа дэвшүүлж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы ерөнхий санал шүүмжлэлд үг хэлэхдээ санаачилгаа дэлхий дахинд зарласан билээ.

Энэ санаачилга маань Байнга товийг сахих тухай Монгол Улсын хууль болон УИХ-д оргон баригдсан. Хэдийгээр санаачилга, түүний үндсэн дээр боловсруулагдсан хууль гэж үзэж болох боловч үнэндээ шинэ алхам биш гэдгийг Та бүхэн мэднэ.

Монгол Улс олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогоо явуулж ирсэн сүүлийн 20 гаруй жилд олон улсын тавцанд үндсэндээ товийг сахисан бодлого баримталсан. Монгол Улс бол энхийг эрхэмлэгч, нээлттэй, ардчилсан улс. Тэр хэрээрээ олон тулгуурт, прагматик гадаад бодлого явуулдаг. Гадаадын ямарваа улс оронтой ашиг сонирхлын зорчил байхгүй, нутаг дэвсгэрийн маргаан байхгүй. Олон улсын харилцааны тулгамдсан асуудлаар бид аль нэг гүрнийг аялдан дагалддаггүй, их гүрнүүдийн маргаан зорчилд хондлонгоос оролцдоггүй, аль нэг талд нь зогсдоггүй, энэ бүхэн маань товийг сахисан бодлого байсан юм.

Иймд товийг сахих тухай Монгол Улсын байр суурийг зовоор ойлгож, дэмжихийг толоолон суугаа улс орнуудынхаа тор-засагт уламжлахыг Та бүхнээс дахин хүсч байна.

Монгол Улстай хоёр талын харилцаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлэх, Монгол Улсын олон улсын байр суурийг дэмжих, олон улсын тавцанд хамтран ажиллах талаар Та бүхний туслалцаа дэмжлэгийг бид цаашид ч авах болно.

2016 он Та бидний найрсаг хамтын ажиллагааны ололтын жил байх болтугай. Анхаарал тавьсанд баярлалаа” гэлээ.

Бичсэн hanoi

2016 оны 1-р сарын 15, Баасан гариг, 08:15 -

---

